



УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Х.БААСАНЖАРГАЛ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

Төрийн ордон, Жинхэнэ Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201

Утас: (976-51) 26 08 17 Факс: (976-51) 26 24 08.

Цахим шуудан: info@cabnet.gov.mn.

Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2026.07.23 № ХЭГ/2513

танай _____-ны № _____-т

Асуулгын хариу хүргүүлэх тухай

"Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 61 дүгээр тогтоолын хэрэгжилт, үр дүнгийн талаар Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан асуулгын хариуг эрхлэх асуудлын дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайдаас бэлтгэн ирүүлснийг Танд хүргүүлж байна.

Хавсралт 43 хуудаастай.



Монгол Улсын Засгийн газар

Засгийн газрын Хэрэг эрхлэх газар

Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга

Баттөмөр Энхбаяр

2026.07.24 12:13



МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА Б.ЭНХБАЯР ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26-75-33
Цахим шуудан: info@mojha.gov.mn
Цахим хуудас: www.mojha.gov.mn

2026.07.09 № 1/3865
танай 2026.06.30 -ны № ХЭГ/2354 -т

Асуулгын хариу хүргүүлэх тухай

Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргалаас “Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2025 оны 61 дүгээр тогтоолын хэрэгжилттэй холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан Асуулгын хариуг хүргүүлж байна.

Асуулга 1. Хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 27¹ дүгээр зүйлийн 27^{1.1}, 27^{1.2} дахь хэсэгт нийцүүлэх зорилгоор судалгаа хийж, холбогдох хуулийн төслийг 2026 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн дотор Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх заалтын хэрэгжилтийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, ажлын одоогийн явц, цаашид энэ заалтын хэрэгжилтийг хангах талаарх төлөвлөлт:

“Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2025 оны 61 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах ажлыг Засгийн газрын түвшинд зохион байгуулах, эрчимжүүлэх үүднээс Засгийн газрын 2025 оны 12, дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаас “Захиргааны хэм хэмжээний актыг хууль тогтоомжид нийцүүлэх зарим арга хэмжээний тухай” 206 дугаар тогтоолыг баталсан.

Засгийн газрын дээрх тогтоолоор эрхлэх асуудлын хүрээнд хамаарах захиргааны хэм хэмжээний актын хууль зүйн үндэслэлийг нягтлан шалгаж, хуульд нийцээгүй, хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан, авлига, ашиг сонирхлын зөрчил гарах нөхцөл бүрдүүлсэн, зөвшөөрлийн шинжтэй зохицуулалт агуулсан болон холбогдох хууль тогтоомж шинэчлэн батлагдсан, нэмэлт, өөрчлөлт орсон, эсхүл хүчингүй болсонтой холбогдуулан дагаж мөрдөхгүй болсон захиргааны хэм хэмжээний актыг хүчингүй болгож, хууль тогтоомжид нийцүүлэх, мөн захиргааны хэм хэмжээний актаар зохицуулж байгаа харилцааг хуулиар зохицуулах хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх тодорхой арга хэмжээ авахыг Засгийн газрын бүх гишүүдэд даалгаж, Улсын Их Хуралд ажлаа хариуцан тайлагнадаг байгууллагуудад зөвлөсөн.

Монгол Улсын Ерөнхий сайдын 2026 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 15 дугаар захирамжаар Засгийн газрын гишүүдийн эрхлэх асуудлын хүрээнд

хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт, бусад дүрэм, журамд дүн шинжилгээ хийж, тэдгээрийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 27¹ дүгээр зүйлд нийцүүлэх, хүчингүй болгох, холбогдох хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулж, Хууль зүй, дотоод хэргийн сайдаар ахлуулж, яамдын дэд сайд нарыг гишүүдээр оруулсан.

Улмаар Засгийн газар шинээр эмхлэн байгуулагдсантай холбогдуулан Ерөнхий сайдын 2026 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 124 дүгээр захирамжаар дээрх Ажлын хэсгийг Төрийн нарийн бичгийн дарга, Шадар сайдын Ахлах зөвлөх бөгөөд Ажлын албаны дарга нарын бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулан ажиллаж байна.

Энэ хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн сайдаас Ажлын хэсгийн үйл ажиллагаанд баримтлах Удирдамжийг батлан, Ажлын хэсгийн хурлыг энэ хугацаанд 2 удаа зохион байгуулж хуралдуулан, удирдамжийн дагуу яам бүрт дэд ажлын хэсэг байгуулах замаар өөрийн эрхлэх асуудлын хүрээнд болон харьяа агентлаг, байгууллагын баталсан дүрэм, журамд дүн шинжилгээ хийх ажлыг эрчимжүүлэх, уг дүн шинжилгээнд үндэслэн хууль тогтоомжтой зөрчилдсөн, хуулиар эрх олгоогүй байхад баталж мөрдүүлсэн, хуулиар зохицуулах ёстой харилцааг журамласан шийдвэрүүдийг хүчингүй болгож дүн шинжилгээг хийж, хуулиар зохицуулах шаардлагатай харилцааг хуульд тусгах чиглэлээр хуулийн төсөл боловсруулах арга хэмжээг авч, үр дүн, тайланг тус яаманд ирүүлэх чиглэлийг өгсөн.

Мөн захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлтэй шийдвэрүүдийг салбар бүрээр ангилан гаргаж, зөвлөмж, удирдамж бүхий хугацаатай албан бичгийг удаа дараа нийт 131 захиргааны байгууллагад хүргүүлж, дүн шинжилгээ хийх ажлыг мэргэжил, арга зүйгээр ханган ажиллаж байна.

1.Хууль зүй, дотоод хэргийн салбарын тухайд:

Хууль зүй, дотоод хэргийн яам өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хууль, дүрэм, журамд дүн шинжилгээ хийж холбогдох хуулийн төсөл боловсруулах арга хэмжээг үе шаттай төлөвлөн авч хэрэгжүүлж байгаа бөгөөд одоогийн байдлаар дараах явцтай байна. Үүнд:

-Хууль зүй, дотоод хэргийн яамнаас боловсруулж, өргөн мэдүүлсэн хүний эрхийг хангах багц хуулийн төслийн хүрээнд боловсруулсан Хууль зүйн туслалцааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд журам батлах эрх олгосон 4 заалтыг хүчингүй болгохоор тусгасан бөгөөд хуулийн төслийг Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэн батлав;

-Галт зэвсгийн тухай хуульд журам батлах эрх олгосон нийт 15 заалт тусгасны 10 заалтыг хүчингүй болгож, журмаар зохицуулж байсан харилцааг хуулиар зохицуулахаар Галт зэвсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж Засгийн газрын 2026 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтоод байна;

-Нотариатын тухай хуулиар журам батлах эрх олгосон нийт 10 заалт тусгагдсанаас 6 заалтыг хүчингүй болгож, журмаар зохицуулж байсан харилцааг хуулиар зохицуулахаар, эрх зүйн ач холбогдлоо алдсан 2 эрх олгосон заалтыг хуулиас хүчингүй болгож хасахаар Нотариатын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын 2026 оны 07 дугаар

сарын 01-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтоод байна;

-Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай багц хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын 2026 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтсон бөгөөд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд 5 журмаар зохицуулж байсан харилцааг хуулиар зохицуулахаар, 4 эрх олгосон заалтын хүрээг хумьж, үндсэн зохицуулалтыг хуулийн төсөлд тусгаж, эрх олгосон зохицуулалтыг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагад нийцүүлж тусгав.

Цаашид тус яамнаас дүрэм, журмаар зохицуулсан харилцааг хуульд тусгах, шаардлагагүй эрх олгосон зохицуулалтыг хүчингүй болгох үүднээс 20 гаруй хуулийн төслийг Улсын Их Хурлын 2026 оны намрын ээлжит чуулганы хугацаанд өргөн мэдүүлэхээр төлөвлөн боловсруулж байна.

2.Бусад захиргааны байгууллагын тухайд:

2026 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн байдлаар Захиргааны 10 байгууллагаас 23 захиргааны хэм хэмжээний актаар зохицуулж байгаа харилцааг хуульд тусган, хүчингүй болгох, 14 эрх олгосон заалтыг хүчингүй болгох, 9 эрх олгосон заалтад нэмэлт, өөрчлөлт оруулахаар нийт 42 хуулийн төсөл боловсруулах мэдээлэл ирүүлснээс Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Сонгуулийн ерөнхий хороо, Санхүүгийн зохицуулах хороо тус тус хуулийн төслүүдийн хэрэгцээ, шаардлагын судалгааны ажлыг эхлүүлсэн талаарх мэдээллийг ирүүлсэн. (Жагсаалтыг албан бичгийн 1 дүгээр хавсралтаас үзнэ үү.)

Асуулга 2.Монгол Улсын нэгдэн орсон олон талт олон улсын гэрээний хянан баталгаажуулсан орчуулга, тэдгээрийн эх бичвэрийг эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд 2026 онд багтаан бүрэн эхээр байршуулах ажлын явцын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, цаашдын арга хэмжээний төлөвлөлтийн талаар:

Өнөөдрийн байдлаар Монгол Улсын нэгдэн орсон олон талт олон улсын гэрээг Төрийн мэдээлэл эмхэтгэлд нийт 15 удаагийн тусгай дугаарт 2014-2021 оны хооронд хэвлэн нийтлүүлсэн ба нийт Монгол Улсын нэгдэн орсон олон талт олон улсын гэрээг бүрэн хамраагүй байна.

Түүнчлэн, Олон улсын гэрээний тухай хууль болон Хууль тогтоомжийн тухай хуулиар Монгол Улсын олон улсын гэрээг (үүнд олон улсын гэрээний тухай хуулиар тодорхойлсноор олон талт болон хоёр талт олон улсын гэрээ орно) хэвлэн нийтлүүлэх ажлыг хэд хэдэн байгууллагад үүрэг болгосон байдаг. Тухайлбал, Олон улсын гэрээний тухай хуулийн 30.1-д "Улсын Их Хурал соёрхон баталсан олон улсын гэрээг тухайн олон улсын гэрээг соёрхон баталсан хуулийн хамт "Төрийн мэдээлэл" эмхэтгэлд нийтэлнэ" гэж заасан бол 30.2-т "Засгийн газар баталсан олон улсын гэрээг тухайн олон улсын гэрээг баталсан тогтоолын хамт Засгийн газрын тогтоолыг нийтлэх журмын дагуу нийтэлнэ" гэж тус тус зохицуулсан байна.

Эдгээр зохицуулалтын хүрээнд одоогийн байдлаар Эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд "Олон улсын гэрээ" гэх ангилалд зөвхөн соёрхон баталсан олон талт болон хоёр талт олон улсын гэрээ байршсан байх ба бусад хоёр талт олон улсын гэрээг баталсан тогтоолыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар Засгийн газрын тогтоол хэсэгт байршуулж байна.

Үүнээс гадна, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн А/128 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, ашиглах журам"-ын 3.3-т заасны дагуу "Монгол Улсын Олон улсын гэрээ, Олон талт Олон улсын гэрээ"-г Гадаад харилцааны яам нь "Төрийн мэдээлэл эмхэтгэл"-д нийтлэгдсэнээс хойш ажлын 5 өдрийн дотор байршуулах зохицуулалттай тул "Төрийн мэдээлэл эмхэтгэл"-д нийтлэгдээгүй Монгол Улсын олон талт олон улсын гэрээг Гадаад харилцааны яам Эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд шууд байршуулах боломжгүй байна.

Иймд гишүүний асуулгад дурдсан "Монгол Улсын нэгдэн орсон олон талт олон улсын гэрээний хянан баталгаажуулсан орчуулга, тэдгээрийн эх бичвэрийг эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд 2026 онд багтаан бүрэн эхээр байршуулах" ажлыг хэрэгжүүлэхэд дараах ажлыг шат дараатай хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Үүнд: 1. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд Монгол Улсын бүх олон талт олон улсын гэрээг нөхөж нийтлэх ажлыг зохион байгуулахын тулд эхний ээлжинд системийн шинэчлэлийг хийж, Олон улсын гэрээний тухай хуульд нийцүүлэн одоогийн "Олон улсын гэрээ" гэх сонголтыг Хоёр талт болон Олон талт олон улсын гэрээ гэсэн тусдаа ангилалтай болгох. Улмаар Засгийн газрын түвшинд баталдаг эсхүл соёрхон баталдаг эсэхээс үл хамааран бүх олон улсын гэрээг зөвхөн тухайн "Олон улсын гэрээ" хэсэгт байршуулах боломжийг бүрдүүлэх. (Энэ асуудлаар Гадаад харилцааны яам Хууль зүйн үндэсний хүрээлэнтэй хамтран "legalinfo" сайтыг хөгжүүлдэг компанитай уулзалт хийж, техникийн даалгавар өгсөн ба урьдчилсан байдлаар гарах зардлын төсвийг аваад байна).

2.Төрийн мэдээлэл эмхэтгэлд нийтлэгдээгүй олон талт олон улсын гэрээг Улсын Их Хурлын Тамгын газартай хамтран Төрийн мэдээлэл эмхэтгэлд нөхөн нийтлүүлж, улмаар дээр дурдсан журмын дагуу Эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд нөхөж байршуулах боломжийг бүрдүүлэх зэрэг болно.

Асуулга 3. Хууль санаачлагчид мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх үүрэг бүхий төрийн холбогдох байгууллагын албан хаагчдыг Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан холбогдох аргачлал, арга зүйгээр хангах, чадавхжуулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулж, хэрэгжүүлэх заалтын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүнгийн талаарх мэдээлэл:

Улсын Их Хурлын 2025 оны 61 дүгээр тогтоолын 1-д заасан "Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт заасан холбогдох аргачлалыг шинэчлэн боловсруулж, батлах"-ыг Засгийн газарт даалгасан арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2026 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн А/48 дугаар тушаалаар Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 59 дүгээр тогтоолоор баталсан "Аргачлал"-ыг шинэчлэн боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг, мөн аргачлал бүрийг боловсруулах чиг үүрэг бүхий Дэд ажлын хэсгийг тус тус байгуулан 2026 оны 3 дугаар улиралд багтаан Засгийн газрын тогтоолоор батлуулахаар төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Ажлын хэсэгт Улсын Их Хурлын Тамгын газар, Хүний эрхийн Үндэсний Комисс, Жендэрийн Үндэсний хорооны ажлын алба, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Хууль зүй, дотоод хэргийн яам болон холбогдох яамд, Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэн, Хууль зүйн үндэсний хүрээлэн, Монгол Улсын Их

Сургуулийн Хууль зүйн сургууль, Монголын Хуульчдын Холбоо, "Нээлттэй нийгэм форум" ТББ зэрэг байгууллагуудын төлөөлөл орсон.

Аргачлалын төслийг боловсруулж, төрийн болон төрийн бус байгууллага, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагын төлөөллийг оролцуулсан олон нийтийн хэлэлцүүлгийг 2026 оны 05 дугаар сарын 22-ны өдөр хийсэн бөгөөд Аргачлалын төслийг Засгийн газраар хэлэлцүүлж, батлуулсны дараа аргачлал бүрээр үндэсний сургагч багшийг бэлтгэх сургалтыг зохион байгуулж, тэдгээрээр дамжуулан холбогдох төрийн захиргааны төв байгууллага болон бусад байгууллагад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх сургалтыг 2026 оны 4 дүгээр улиралд хийхээр төлөвлөн ажиллаж байна.

Асуулга 4. Хуулиар тусгайлан эрх олгогдоогүй бөгөөд нийтээр заавал дагаж мөрдүүлэхээр баталсан дүрэм, журам, заавар, аргачлалыг хүчингүй болгох ажлын явц, үр дүнгийн талаарх дүгнэлт, мэдээлэл:

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас захиргааны хэм хэмжээний акт баталсан байгууллагуудад захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлтэй шийдвэрээс гадна хянуулж, бүртгүүлэлгүйгээр нийтээр дагаж мөрдүүлж байгаа дүрэм, журам, бусад хэм хэмжээ тогтоосон шийдвэрт дүн шинжилгээ хийх чиглэлийг хүргүүлсэн.

Энэ хүрээнд ирүүлсэн тайлангаас үзэхэд одоогийн байдлаар хуулиар тусгайлан эрх олгогдоогүй байхад баталж, нийтээр дагаж мөрдүүлж байсан 10 байгууллага 9 дүрэм, журмыг хүчингүй болгож, 10 байгууллага 24 дүрэм, журмыг хүчингүй болгох ажиллагааг хийж байна. (Жагсаалтыг албан бичгийн 2 дугаар хавсралтаас үзнэ үү.)

Асуулга 5. Хуульд заасны дагуу баталсан боловч бүртгүүлээгүй захиргааны хэм хэмжээний актыг улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх заалтын хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаарх мэдээлэл:

Хуулиар эрх олгосны дагуу баталсан боловч захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэлгүй дагаж мөрдүүлж байсан 2 дүрэм, журмыг нөхөн бүртгүүлсэн бөгөөд 15 байгууллагын 31 дүрэм, журмыг Захиргааны ерөнхий хуульд заасан шаардлагад нийцүүлэн нөхөн бүртгүүлэх ажиллагаа хийгдэж байна. (Жагсаалтыг албан бичгийн 3 дугаар хавсралтаас үзнэ үү.)

Асуулга 6. Эрх зүйн зохицуулалтын ач холбогдлоо алдаж дагаж мөрдөхгүй болсон, хууль тогтоомжтой зөрчилдсөн, эрх олгосон хуулийн заалт нь хүчингүй болсон, өөрчлөгдсөн захиргааны хэм хэмжээний актыг хүчингүй болгох, хуульд нийцүүлэн шинэчлэн батлах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүнгийн талаарх мэдээлэл:

Захиргааны хэм хэмжээний актад дүн шинжилгээ хийж, хууль тогтоомжид нийцүүлэх ажлын хүрээнд 2026 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн байдлаар Засгийн газрын гишүүн, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын дарга, агентлагийн дарга, бусад зөвлөл, хороо, комисс, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга зэрэг нийт 30 байгууллагын 81 дүрэм, журмыг хууль тогтоомжтой зөрчилдсөн, хуулиар тусгайлан эрх олгоогүй байхад баталсан, тусгайлан эрх олгосон хуулийн заалт хүчингүй болсон, өөрчлөгдсөн, эрх зүйн ач холбогдлоо алдсан, үндэслэлээр хүчингүй болгож, 4 байгууллага 5 дүрэм, журмыг хуульд нийцүүлэн шинэчлэн баталж, 5 байгууллага 13 дүрэм, журамд нэмэлт, өөрчлөлт оруулсан.

(Жагсаалтыг албан бичгийн 4 дүгээр хавсралтаас үзнэ үү.)

Түүнчлэн, 2025 оны 07 дугаар сараас 2026 оны 07 дугаар сар хүртэлх хугацаанд Хууль зүй, дотоод хэргийн яамнаас захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлтэй болон хянуулж, бүртгүүлэхээр ирүүлсэн нийт 160 дүрэм, журмыг Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид нийцүүлэх, журмын тодорхой зохицуулалтыг тусгайлан эрх олгосон хуулийн агуулга, зорилго, хүрээнд нийцүүлэх, хуулиар хориглоогүй асуудлаар хориглосон зохицуулалтыг хүчингүй болгох, тухайн дүрэм, журмыг хэрэгжүүлснээр эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх бүлгийн хүрээнд хэлэлцүүлэг зохион байгуулж саналаа тусгуулах эрхийг хангах, эерэг болон сөрөг талуудыг харьцуулан судалж, дүрэм, журмын эдийн засаг, нийгмийн амьдралд үзүүлэх нөлөөлөл, үр дагаврыг урьдчилан тооцоолох чиглэлээр нөлөөллийн шинжилгээг хийх зэрэг үндэслэлээр зөрчлийг арилгуулахаар дүгнэлт хүргүүлж ажиллаж байна.

Асуулга 7. Эрхлэх асуудлын хүрээнд хамаарах захиргааны хэм хэмжээний актын хууль зүйн үндэслэлийг нягтлан шалгаж, хуулиар тогтоосон хязгаарлалтаас гадуур хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан, ашиг сонирхлын зөрчил, авлига гарах нөхцөл боломж бүрдүүлсэн шинжтэй дүрэм, журам, тэдгээрийн холбогдох зохицуулалтыг хүчингүй болгох, өөрчлөх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүнгийн талаарх мэдээлэл:

Авлигатай тэмцэх газрын 2024 оны 01/17288 тоот албан бичгээр ирүүлсэн “журмын зарим зохицуулалт авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх эрсдэлтэй, албан тушаалтанд албаны бүрэн эрхээ урвуулан ашиглаж, бусдад давуу байдал олгох, ашиг хонжоо олох нөхцөлийг бүрдүүлсэн нөхцөл байдал тогтоогдсон” талаарх зөвлөмж, түүнчлэн Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсантай холбогдуулан эрх олгосон заалт хүчингүй болсон үндэслэлээр хүчингүй болгосон 1, Гаалийн ерөнхий газраас журмын зохицуулалт авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх, гаалийн хилээр нэвтрүүлэх шат дамжлагыг нэмэгдүүлсэн, ойлгомжгүй нөхцөл байдал үүсгэх эрсдэлтэй гэж дүгнэсэн үндэслэлээр хүчингүй болгож, эдгээр эрсдэлийг арилган шинэчлэн баталсан 1 захиргааны хэм хэмжээний акт байна. (Жагсаалтыг албан бичгийн 5 дугаар хавсралтаас үзнэ үү.)

Асуулга 8. Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг хуульд нийцүүлэн хийж, үнэлгээг эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд тогтмол байршуулах ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүнгийн талаарх мэдээлэл:

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан, мэдээллийн нэгдсэн системийг хөгжүүлж байгаа бөгөөд Улсын Их Хурлын хяналт, шалгалтын мэдээллийн нэгдсэн сан /monitoring.parliament.mn/-д Хууль зүй, дотоод хэргийн яаманд хуваарилагдсан нийт 80 хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний судалгааны талаарх мэдээлэл, тайланг 2026 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн дотор уг системд байршуулж, тайланг илгээсэн.

Эдгээр 80 хуулиас 45 хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийсэн судалгааг системд оруулсан бөгөөд 6 хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийгдэж байгаа, Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3 дахь хэсэгт заасан хуулийн хэрэгжилтийн үр дагавар хийх хугацаа болоогүй, хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийх хэрэгцээ, шаардлагатай боловч

төлөвлөгдсөн төсөв хасагдсаны улмаас хуулийн хэрэгжилтийн үр дагавар хийгдээгүй 29 хууль байна. (Жагсаалтыг албан бичгийн 6 дугаар хавсралтаас үзнэ үү.).

Хавсралт 36 хуудастай.



Хууль зүй, дотоод хэргийн яам
Удирдлага
Сайд
Сайнбуян Амарсайхан
2026.07.20 15:08

Хууль зүй, дотоод хэргийн сайдын
2026 оны 07 дугаар сарын 02-ний
өдрийн 1395 тоот албан бичгийн
1-р хавсралт

Хүснэгт 1. Захиргааны хэм хэмжээний актаар зохицуулж байгаа харилцааг хуульд тусган, эрх олгосон заалтыг хүчингүй болгох, эрх олгосон заалтад нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулахаар ирүүлсэн саналын жагсаалт:

Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсны үндсэн дээр хүчингүй болгох захиргааны хэм хэмжээний актын мэдээлэл			
д/д	Боловсруулсан болон боловсруулах санал ирүүлсэн хуулийн төсөл	Журмын мэдээлэл	Санал боловсруулсан байгууллага
1.1	Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны А/158 дугаар тушаалаар баталсан "Тусгай мэдлэг бүхий хүнд шинжээчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, сэргээх, сунгах, хүчингүй болгох санал, дүгнэлт гаргах эрх бүхий орон тооны бус зөвлөлийн үйл ажиллагааны журам"	Шүүх шинжилгээний ерөнхий газар
1.2	Шүүх шинжилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл		Шүүх шинжилгээний ерөнхий газар
1.3	Галт зэвсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны А/383, А/112 дугаар хамтарсан тушаалаар баталсан "Спорт-сургалтын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий иргэн, хуулийн этгээдийн галт зэвсэг эзэмших, хадгалах журам"	Хууль зүй, дотоод хэргийн яам
1.4	Галт зэвсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны А/384, А/113 дугаар хамтарсан тушаалаар баталсан "Буудлага үйлдэх байгууламж /тир/-д тавигдах шаардлага"	Хууль зүй, дотоод хэргийн яам
1.5	Галт зэвсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл	Хууль зүйн сайдын 2015 оны А/245 дугаар тушаалаар баталсан "Иргэний болон харуул хамгаалалтын зориулалттай галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг импортлох, нийтэд худалдах тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журам", "Галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл худалдах төвд эрх олгох, салбар нээх болон төвийн зохион байгуулалт, үйл ажиллагаа, аюулгүй байдлыг хангах журам"	Хууль зүй, дотоод хэргийн яам

1.6	Галт зэвсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл	Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны А/74 дүгээр тушаалаар баталсан "Галт зэвсгийг Монгол улсын хилээр нэвтрүүлэх зөвшөөрлийн загвар"	Хууль зүй, дотоод хэргийн яам
1.7	Галт зэвсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл	Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны А/73 дугаар тушаалаар баталсан "Борлуулагчийн галт зэвсгийн бүртгэлийн загвар", "Борлуулагчийн сумны бүртгэлийн загвар"	Хууль зүй, дотоод хэргийн яам
1.8	Галт зэвсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл	Хууль зүйн сайдын 2015 оны А/220 дугаар тушаалаар баталсан "Галт зэвсгийн тооллого явуулах журам"	Хууль зүй, дотоод хэргийн яам
1.9	Галт зэвсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл	Хууль зүйн сайдын 2015 оны А/219 дүгээр тушаалаар баталсан "Хураагдсан галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг устгах, худалдах, өмчлөгчид буцаан олгох, шилжүүлэх журам"	Хууль зүй, дотоод хэргийн яам
1.10	Галт зэвсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл	Хууль зүй, дотоод хэргийн сайд, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2025 оны А/385, А/114, А/831 дүгээр хамтарсан тушаалаар баталсан "Иргэний болон харуул хамгаалалтын ангилалд хамаарах галт зэвсэг, сумны нэр, төрлийн жагсаалт"	Хууль зүй, дотоод хэргийн яам
1.11	Нотариатын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	Хууль зүйн сайдын 2016 оны А/06 дугаар тушаалаар баталсан "Нотариатчийн мэргэшлийн хорооны ажиллах журам"	Хууль зүй, дотоод хэргийн яам
1.12	Нотариатын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2011 оны 123 дугаар тушаалаар баталсан "Нотариатын үйлчилгээний хөлс, зардлын хэмжээ"	Хууль зүй, дотоод хэргийн яам
1.13	Оюуны өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны А/11 дүгээр тушаалаар баталсан "Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журам"	Оюуны өмчийн газар
1.14	Оюуны өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны А/17 дугаар тушаалаар баталсан "Хамтын удирдлагын байгууллагын үйл ажиллагаанд баримтлах журам"	Оюуны өмчийн газар
1.15	Оюуны өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	Оюуны өмчийн газрын даргын 2021 оны А/08 дугаар тушаалаар баталсан "Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн ажиллах журам"	Оюуны өмчийн газар

1.16	Зохиогчийн эрхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	Оюуны өмчийн газрын даргын 2022 оны А/137 дугаар тушаалаар баталсан "Хамтын удирдлагын байгууллагын гүйцэтгэх удирдлага болон ажилтанд сургалт зохион байгуулах журам"	Оюуны өмчийн газар
1.17	Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	Сонгуулийн ерөнхий хорооны 2021 оны 32 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулиар радио, телевизээр сонгуулийн сурталчилгааг нэвтрүүлэх, хяналт тавих журам"	Сонгуулийн ерөнхий хороо
1.18	Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	Сонгуулийн ерөнхий хорооны 2024 оны 14 дүгээр тогтоолоор баталсан "Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих журам"	Сонгуулийн ерөнхий хороо
1.19	Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	Сонгуулийн ерөнхий хорооны 2024 оны 12 дугаар тогтоолоор баталсан Радио, телевизээр сонгуулийн сурталчилгааг нэвтрүүлэх, хяналт тавих, радио, телевизийг бүртгэх, бүртгэхээс татгалзах журам	Сонгуулийн ерөнхий хороо
1.20	Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	Сонгуулийн ерөнхий хорооны 2024 оны 201 дүгээр тогтоолоор баталсан "Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих журам"	Сонгуулийн ерөнхий хороо
1.21	Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	Сонгуулийн ерөнхий хорооны 2024 оны 202 дугаар тогтоолоор баталсан "Радио, телевизээр сонгуулийн сурталчилгааг нэвтрүүлэх, хяналт тавих журам"	Сонгуулийн ерөнхий хороо
1.22	Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2024 оны А/102 дугаар тушаалаар баталсан "Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг олгох сонгон шалгаруулалтын журам"	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам
1.23	Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	Уул уурхайн сайдын 2014 оны 202 дугаар тушаалаар баталсан "Гэрээлэгчийг сонгон шалгаруулах журам"	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам
1.24	Газрын тосны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл		Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам
1.25	Малын генетик нөөцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2022 оны А/405 дугаар тушаалаар баталсан "Малын бүртгэлийн журам"	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
1.26	Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2022 оны А/282 дугаар тушаалаар	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам

		баталсан "Малын удам зүйн үнэлгээний бүртгэлийн журам"	
1.27	Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд, Эрүүл мэндийн сайдын 2013 оны А/46/115 дугаар хамтарсан тушаалаар баталсан "Зайлшгүй сав, баглаа боодол болон шошго хэрэглэх хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний төрлийг тодорхойлох, шошголох журам"	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
1.28	Хоршооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А-295 дугаар тушаалаар баталсан "Улсын шилдэг хоршоог шалгаруулах, шагнах журам"	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
1.29	Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А-254 дүгээр тушаалаар баталсан "Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээний цахим мэдээллийн санг бүрдүүлэх, хөтлөх, мэдээлэл цуглуулах, үйлчилгээ үзүүлэх журам"	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
1.30	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл	Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/114 дүгээр тушаалаар баталсан "Аж ахуйн нэгж, байгууллагын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн ажиллах үлгэрчилсэн журам"	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
1.31	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны А/130 дугаар тушаалаар баталсан "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт зохион байгуулах журам"	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
1.32	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/155 дугаар тушаалаар баталсан "Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх журам"	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
1.33	Шуудангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын даргын 2020 оны 2020 оны А/53 дугаар тушаалаалаар баталсан "Шуудангийн үйлчилгээ үзүүлэхэд мөрдөх дүрэм"	Цахим хөгжил, иновац, харилцаа холбооны сайд
1.34	Шуудангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын даргын 2020 оны А/55 дугаар тушаалаалаар баталсан "Шуудангаар үйлчлэгч болон шуудангийн илгээмж тээвэрлэгч этгээдийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах журам"	Цахим хөгжил, иновац, харилцаа холбооны сайд
1.35	Радио долгионы тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын даргын 2020 оны А/47 дугаар тушаалаалаар	Цахим хөгжил, иновац, харилцаа холбооны сайд

		баталсан "Радио давтамжийн нэгдсэн бүртгэлийн журам"	
1.36	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	Хууль зүй, дотоод хэргийн сайд, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын хамтарсан 2022 оны А/268, А/48 дугаар тушаалаар баталсан "Нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг зохион байгуулах, үнэлгээ хийх, зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий, орон тооны бус зөвлөлийн ажиллах журам, Зөвлөлийн бүрэлдэхүүн"	Цахим хөгжил, иноваци, харилцаа холбооны сайд
1.37	Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд, Тагнуулын ерөнхий газрын даргын 2024 оны А/30, А/148 дугаар хамтарсан тушаалаар баталсан "Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх журам, аргачлал"	Цахим хөгжил, иноваци, харилцаа холбооны сайд
1.38	Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл	Хууль зүй, дотоод хэргийн сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2001 оны 100/32 дугаар хамтарсан тушаалаар баталсан "Гадаадын иргэнд Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлүүлэх журам"	Гадаадын иргэн, харьяатын газар
1.39	Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл	Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2011 оны 52 дугаар тушаалаар баталсан "Барьцаа гаргуулах, буцаан олгох, барьцааны хэмжээг тогтоох журам"	Гадаадын иргэн, харьяатын газар
1.40	Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл	Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны А/08 дугаар тушаалаар баталсан "Олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газарт Монгол Улсад үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох, үйл ажиллагаанд нь хяналт тавих журам"	Гадаадын иргэн, харьяатын газар
1.41	Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл	Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газрын даргын 2016 оны А/284 дүгээр тушаалаар баталсан "Гадаадын иргэнд Монгол Улсад хувийн хэргээр зорчих урилга олгох журам"	Гадаадын иргэн, харьяатын газар
1.42	Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл	Гадаадын иргэн, харьяатын газрын даргын 207 оны А/111 дүгээр тушаалаар баталсан "Гадаадын иргэнийг Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлэх, гарахыг түдгэлзүүлэхийг хүчингүй болгох тухай шийдвэр"	Гадаадын иргэн, харьяатын газар

		гаргах, түүнийг хэрэгжүүлэх журам"	
1.43	Жолоочийн даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл	Санхүүгийн зохицуулах хороо, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019 оны 29/А/13 дугаар хамтарсан тогтоол, тушаалаар баталсан "Жолоочийн даатгалын баталгааны загвар, түүнийг хэрэглэх журам"	Санхүүгийн зохицуулах хороо
1.44	Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	-	Санхүүгийн зохицуулах хороо
1.45	Компанийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл	-	Санхүүгийн зохицуулах хороо
1.46	Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	-	Санхүүгийн зохицуулах хороо
1.47	Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	-	Санхүүгийн зохицуулах хороо
1.48	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	-	Санхүүгийн зохицуулах хороо
1.49	Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	-	Санхүүгийн зохицуулах хороо
1.50	Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	-	Санхүүгийн зохицуулах хороо
1.51	Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	-	Санхүүгийн зохицуулах хороо
1.52	Даатгалын тухай хуульд хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	-	Санхүүгийн зохицуулах хороо
1.53	Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	-	Санхүүгийн зохицуулах хороо
1.54	Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	-	Санхүүгийн зохицуулах хороо
1.55	Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	-	Санхүүгийн зохицуулах хороо
1.56	Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай	-	Санхүүгийн зохицуулах хороо

	хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл		
1.57	Малын генетик нөөцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	Захиргааны хэм хэмжээний акт батлагдаагүй бөгөөд эрх олгосон 3 заалтыг хүчингүй болгох	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
1.58	Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	Захиргааны хэм хэмжээний акт батлагдаагүй бөгөөд эрх олгосон 3 заалтыг хүчингүй болгох	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
1.59	Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	Захиргааны хэм хэмжээний акт батлагдаагүй бөгөөд эрх олгосон 1 заалтыг хүчингүй болгох	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
1.60	Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	Захиргааны хэм хэмжээний акт батлагдаагүй бөгөөд эрх олгосон 1 заалтыг хүчингүй болгох	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
1.61	Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	Захиргааны хэм хэмжээний акт батлагдаагүй бөгөөд эрх олгосон 2 заалтыг хүчингүй болгох	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
1.62	Тариалангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	Захиргааны хэм хэмжээний акт батлагдаагүй бөгөөд эрх олгосон 1 заалтыг хүчингүй болгох	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
1.63	Таримал ургамлын үр, сортын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	Захиргааны хэм хэмжээний акт батлагдаагүй бөгөөд эрх олгосон 1 заалтыг хүчингүй болгох	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
1.64	Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	Захиргааны хэм хэмжээний акт батлагдаагүй бөгөөд эрх олгосон 3 заалтад нэмэлт, өөрчлөлт оруулах	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
1.65	Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	Захиргааны хэм хэмжээний акт батлагдаагүй бөгөөд эрх олгосон 1 заалтад нэмэлт, өөрчлөлт оруулах	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
